



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/133

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3 дэх заалт, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2020 оны 4 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох байгууллага, аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эмийн сангийн стандарт MNS5260:2015, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5203:2002, Ахуйн шавьж мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт, үйлчилгээ MNS5161-3:2002 өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ ЭРДЭНЭ

482010371

Аймгийн Засаг даргын 2020 оны 05-р сарын 06-ны өдрийн 133 дугаар захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хугацаа
1	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	"Уламжлалт анагаах ухааны төв"	Уламжлалт анагаах ухааны оношлогоо, эмчилгээ	ЭУ-15/10/1001	5 жил	2020-01-29 2025-01-29
2	"Мөнхдэлгэр" ХХК	"Мөнхдэлгэр" хувийн эмнэлэг	Дотор, хүүхдийн өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-15/10/1011	5 жил	2020-04-25 2025-04-25
3	"Элбэрэл буян" ХХК	"Элбэрэл буян" хувийн эмнэлэг	Дотор, мэдрэл, уламжлалт өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-15/10/1012	5 жил	2020-04-25 2025-04-25
4	"Манлай-Угалз" ХХК	"E-and оношлогоо" хувийн эмнэлэг	Хэт авиа оношлогоо	ЭСХ-14/02/972	5 жил	2020-04-25 2025-04-25
5	"Галтай хайрхан" ХХК	"Төгс дэлгэц" хувийн эмнэлэг	Хэт авиа оношлогоо	ЭСХ-14/02/973	5 жил	2020-02-25 2025-02-25
6	"Хан түшиг дент" ХХК	"Хан түшиг дент" шүдний эмнэлэг	Нүүр амны өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-17/10/1036	5 жил	2020-04-25 2025-04-25
7	"Номин хаш дент" ХХК	"Хаш" хиймэл шүдний эмнэлэг	Хиймэл шүд хийх	ЭХ-15/10/1014	5 жил	2020-04-25 2025-04-25
8	"Гоогоо долгион" ХХК	"Гоогоо долгион" мэдрэлийн эмнэлэг	Мэдрэлийн эмчийн оношлогоо, эмчилгээ, тархины цахилгаан бичлэг	ЭХ-16/10/1035	5 жил	2020-03-22 2025-03-22

9	"Тавин-Ус" ХХК	"Тавин-Ус" эм ханган нийлүүлэх байгууллага	Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх	ХХ-15/10/1019	5 жил	2020-04-25 2025-04-25
10	"МНЧ" ХХК	"МНЧ" эмийн сан	1-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1016	5 жил	2020-04-25 2025-04-25
11	"Ундрам мандал" ХХК	"Буяндэлгэр" эмийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1015	5 жил	2020-04-25 2025-04-25
12	"Сайн түшиг" ХХК	"Сайн түшиг"	Ахуй шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ	АҮХ-16/10/1034	3 жил	2020-04-25 2023-04-25
13	"Олонлог ЭМЗ"	"Олонлог" хүүхдийн эмнэлэг	Хүүхдийн өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-20/10/1042	3 жил	2020-05-04 2023-05-04